

UCS ..... 2022



Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага

Улаанбаатар хот  
2022 он

## **АГУУЛГА**

1. ХАМРАХ ХҮРЭЭ .....	3
2. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ .....	3
3. НОРМАТИВ ЭШЛЭЛ.....	3
4. ОРШУУЛГЫН ГАЗРЫН ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА .....	4
5. ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА .....	16
6. ОРШУУЛГЫН ГАЗРЫГ ХААХ ШААРДЛАГА .....	18
7. ОРШУУЛГЫН ГАЗРЫГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ШААРДЛАГА .....	18
8. АНХААРАХ БОЛОН ХОРИГЛОХ ЗҮЙЛС.....	19
9. ШАЛГАХ ХУУДАС .....	21

# ОРШУУЛГЫН ГАЗРЫН ОРЧНЫ ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

---

## 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийслэлд оршуулгын газар төлөвлөх, байгуулах, хамгаалах, арчлах, дахин ашиглах зэрэг үйл ажиллагаанд хамаарна.

## 2. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

**Оршуулгын цогцолбор** – гэж энэхүү стандартаар тогтоосон шаардлагад бүрэн нийцсэн дэд бүтэц, барилга байгууламж, ерөнхий төлөвлөлт бүхий мэргэшсэн байгууллагын удирдамж дор үйл ажиллагаа явуулах газар нутгийг хэлнэ ;

**Хаагдсан оршуулгын газар** – гэж эрх бүхий байгууллагын шийдвэрээр оршуулгын үйл ажиллагаа явуулах буюу оршуулах/оршоохыг хориглосон газрыг хэлнэ;

**Зөвшөөрөлгүй оршуулгын газар** – гэж төрийн ба орон нутгийн захиргааны байгууллагад бүртгэгдээгүй, газар зохион байгуулалтын төлөвлөгөөны дагуу олгосон газраас өөр газарт оршоосон газар нутгийг хэлнэ;

**Шилжүүлсэн оршуулга** – гэж зөвшөөрөлтэй оршуулгын газраас бусад газарт далд оршуулсан болон ил тавьсан шарилыг шилжүүлэн байршуулсныг хэлнэ;

**Эрдэсжих** - гэж оршуулсан шарил, цогцос химийн элемент ба энгийн химийн нэгдэл болон задрах үйл явцыг хэлнэ;

**Орчил мөчлөг/эх дэлхийд шингэх/** - гэж газарт оршуулсан шарилд задрал явагдан, газрын хөрсөнд эрдэсжих, газрын гадарга нөхөн төлжиж эдгэх хугацааг хэлнэ;

**Оршуулгын байгууламж** – гэж шарил, чандрыг газар дээр болон газар доор оршоох зорилгоор бүтээсэн байгууламжийг хэлнэ;

**Дурсгалын барилга байгууламж** – гэж тухайлсан түүхэн үйл явдал, хүнд зориулсан дурсгалын биет байгууламж бүхий бүтээлийг хэлнэ.

**Зүлгэн оршуулгын газар** – гэж талбайд бүрэлдээ ямар нэгэн мод бүт тарихгүй бөгөөд ногоон байгууламжийн дан зүлэгжүүлэн шийдсэн талбайг хэлнэ.

**Чандарлах** – гэж шарилыг зориулалтын зууханд шатааж үнс болгох технологийн үйл явцыг<sup>1</sup> хэлнэ.

## 3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад эш татсан дараах хууль, журам, норм дүрэм стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн эх материалыг үндэслэл болгоно.

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Газрын тухай хууль

---


<sup>1</sup> MNS 5605:2006 Шарил чандарлах үйлчилгээний байгууллагад тавигдах ерөнхий шаардлага 4.1. дэх заалт

3. Соёлын өвийг хамгаалах тухай хууль
4. MNS 5105:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага
5. MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
6. MNS 6841:2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага
7. MNS 5605:2006 Шарил чандарлах үйлчилгээний байгуулагад тавигдах ерөнхий шаардлага
8. БНБД 30-01-04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт.

#### 4. ОРШУУЛГЫН ГАЗРЫН ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

5.1. Оршуулгын газрыг хүн амын нягтрал ихтэй, барилгажсан суурин газраас багадаа 20км-н зайтай төлөвлөх нь тохиромжтой.

5.2. Хүн амын ундны усны аюулгүй байдал, хөрс болон агаарын бохирдлыг үүсгэх тул дараах байдлаар төлөвлөнө.



Зураг 1. Оршуулгын төлөвлөлтийн тойм зураг

5.3. Оршуулгын төрөл нь дараахаар байж болно. Үүнд:

- Иргэний
- Цэргийн
- Төрийн
- Албаны
- Шашны зан үйлийн
- Үндэстний
- Гамшиг, онцгой байдлын


5.4. Оршуулгын газар нь хилийн булангийн цэгийг тогтоосон шав тэмдэгтэй, газрын зөвшөөрөлтэй, гэрчилгээгээр баталгаажсан, хариуцах этгээдтэй байна.

5.5. Чандарлах<sup>2</sup>: Оршуулгын газрын тодорхой хэсгийг чандарласан шарилыг оршуулах зориулалттай болгон төлөвлөж болно. Эдгээр газрууд нь уламжлалт оршуулгын газартай төстэй байхаар төлөвлөх бөгөөд дараах дүрмийг баримтална. Үүнд:

<sup>2</sup> <https://www.hastings.gov.uk/Cemetery-crematorium/grave-types/>

- 1) Хөшөөний чулуу нь 75 см өндөр 60 см өргөнөөс ихгүй байж болно. Суурь нь 60 см өргөн, 30 см гүнээс хэтрэхгүй байна.
- 2) Дурсгалын хананд бумба байрлуулж болно.
- 3) Мод болон төмрөөр хийсэн байнгын дурсгалыг хориглоно.
- 4) Цэцэрлэгийн зориулалтаар талбай төлөвлөхгүй бөгөөд зүлэгжүүлсэн талбайд тарьж, ургуулж, байрлуулж болохгүй.
- 5) Хашаа, хашлага хийхийг хориглоно.

5.6. Оршуулгын газрын төлөвлөлтийг хийхдээ дараах схемд үзүүлсэн нөхцөлүүдийг харгалзан үзвэл зохино<sup>3</sup>.



Схем 1.

5.7. Тухайн газар нутгийн хөгжлийн хэтийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан нийцсэн байх шаардлагатай.

<sup>3</sup> [https://www.researchgate.net/profile/Akebe-Abia/publication/340777817\\_Environmental\\_Risk\\_Assessment\\_Monitoring\\_and\\_Management\\_of\\_Cemeteries/links/5ef47a45299bf15a2ea09e92/Environmental-Risk-Assessment-Monitoring-and-Management-of-Cemeteries.pdf](https://www.researchgate.net/profile/Akebe-Abia/publication/340777817_Environmental_Risk_Assessment_Monitoring_and_Management_of_Cemeteries/links/5ef47a45299bf15a2ea09e92/Environmental-Risk-Assessment-Monitoring-and-Management-of-Cemeteries.pdf)





*Зураг 2. Чандарлах оршуулгын гаднах дурсгалын самбар байрлуулсан жишээ зураг*

**5.8. Зүлгэн оршуулгын газар:** Зүлэгжүүлсэн оршуулгын газрын аль ч хэсэгт мод, бут сөөг тарихыг хориглоно.

5.8.1. Булшны талбайн зүлгийг ямар нэгэн зөвшөөрөлгүй засахыг өрөлцөхыг хориглохоос гадна зүлэгжүүлсэн талбайд ямар ч эд зүйл тавьж болохгүй.



*Зураг 3. Зүлгэн оршуулгын газрын жишээ зураг /талбайн харагдах байдал/*


**5.9. Уламжлалт оршуулгын газар:** Энэ төрлийн оршуулгын төлөвлөлт хийхдээ дараахыг анхаарч үзнэ.

5.9.1. Оршуулгын газарт аль болох жигд байдлыг хангах үүднээс бүх дурсгал, дурсгалт газруудын байрлалыг төлөвлөнө.

5.9.2. Аливаа суурийн чулууны дээд гадаргуу нь эргэн тойрон дахь зүлгийн түвшнээс дор хаяж 2 см-ийн өндөрт байх.

5.9.3. Оршуулгын газарт хөшөө, чулуу, хашлага босгож байгаа, байрлуулж байгаа хүн уг булшийг хийхийн өмнө талийгаачийн нэрийг дээр нь  $\frac{3}{4}$ -аас доошгүй үсгээр сийлбэрлэнэ. Булшны чулууны нүүрэн талд газрын түвшнээс дор хаяж 7.5 см өндөрт сийлсэн байх ёстой. Дараах байдлаар байрлуулж болно.<sup>4</sup>

<sup>4</sup> Газрын тухай хууль, 12 дугаар бүлэг 12.2. Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт



Зураг 3. Дурсамжийн самбар байрлуулсан жишээ зураг

5.10. Оршуулгын газрын байршил, талбайн хэмжээ, хил зааг, хамгаалалтын бүсийг тухайн газрын байгалийн онцлог шинжээс хамаарч, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтооно.

5.11. Оршуулгын газрын үйл ажиллагааны бүс хязгаарыг шаардлага хангасан хашаа, хаалтаар зааглаж, таних тэмдэг, хаяг бичвэр байрлуулна.

5.12. Оршуулгын газрын үйл ажиллагааны бүсэд явган хүн, авто тээврийн хэрэгсэл нэвтрэх орц, гарц, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол, зан үйл гүйцэтгэх байгууламж, ариун цэврийн байгууламж, ногоон байгууламж, цогцос оршуулах /оршоох талбай/ байгууламж зэргийг тухайн газар нутгийн онцлогт тохируулсан төлөвлөнө.

5.13. Оршуулгын газарт оршуулгын цогц үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага байрлаж болох ба хэрэглэгчдэдид шаардлагатай дараах дэд бүтцийг тусгасан байна.<sup>5</sup> Үүнд:

- Орц, гарц
- Авто зогсоол
- Далд оршуулгын газар
- Шарил чандарлах газар
- Зан үйлийн танхим

хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна. 22 дугаар зүйл.Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх


22.1.1.нийтийн эдэлбэрийн газрын ашиглалтыг зохион байгуулах;

22.1.2.баг, хорооны нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэр газрын эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах;

<sup>5</sup> MNS 6841:2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага

- Бунхан
- Суварга
- Ариун цэврийн байгууламж
- Ногоон байгууламж






- ① Газар доорх оршуулга
- ② Газар доорх оршуулга урьдчилан төлөвлөгөөт
- ③ Бүртгэл
- ④ Шарил хадгалах байгууламж
- ⑤ Зан үйлийн байгууламж
- ⑥ Хяналтын пост
- ⑦ Үйлчлүүлэгчдийн авто зогсоол
- ⑧ Чандрын ханан байгууламж
- ⑨ Чандрын байгууламж
- ⑩ Хашаа
- ⑪ Ногоон байгууламж
- ⑫ Инженерийн дэд бүтцийн барилга байгууламж

Зураг 4. Оршуулын газрын гадна талбайн төлөвлөлтийн жишээ зураг /чандарлах оршуулга/

5.14. Оршуулгын газрын хамгаалалтын бүсийг оршуулгын газраас 300м, хот суурин газар, цэвэр ус, булаг шандын эх, аялал жуулчлалын бүсээс 200м-ээс доошгүй зайд байхаар төлөвлөнө.


5.15. Оршуулгын газрыг оновчтой төлөвлөсөн байх ба нийт талбайн 20-иос доошгүй хувьд ногоон байгууламжтай байх.



Зураг 5. Ногоон байгууламжийн төлөвлөлтийг харуулсан жишээ зураг

5.16. Оршуулгын газрын гадна талд тээврийн хэрэгслийн зогсоолыг багадаа 50 автомашины зогсоолын хүчин чадалтайгаар UCS0902B:2022 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавих ерөнхий шаардлага-н дагуу төлөвлөнө.

5.17. Оршуулгын газрын эдэлбэр газарт явган хүний зам, тохижилтыг UCS0901B:2022 Явган хүний зам талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага-н дагуу дараах байдлаар төлөвлөнө.



Зураг 6. Авто зогсоолын төлөвлөлтийг хийх загвар зураг



Зураг 7. Төлөвлөлтийн план, жишээ зураг

5.18. Үйлчилгээний мэдээллийг агуулсан 50х50 см-ээс багагүй хэмжээтэй самбарыг байрлуулсан байна. Гадна талбайн гэрэлтүүлгийг UCS1902A:2022 Гэрэлтүүлэх төхөөрөмжийг төлөвлөх, байрлуулах, суурилуулах удирдамж-н дагуу байрлуулсан байх шаардлагатай.

5.19. Гадна талбайд хогийн савыг байрлуулахдаа UCS1406B:2022 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах хогийн саванд тавих шаардлага-н дагуу байрлуулна. Аюултай хог хаягдлын ангилал, шаардлага хангасан хогийн савыг холбогдох стандартын баримт бичигт заасны дагуу байрлуулан төлөвлөнө.

5.20. Оршуулгын газрын ерөнхий төлөвлөгөөний схем зургийг самбар хэлбэрээр гадна талбайд байрлуулна.

#### **5.21. Оршуулгын байгууламжид тавигдах шаардлага**

5.21.1. Оршуулгын байгууламж нь газар дээр ба доор сүм, суварга, бунхан, ханан байгууламж, хөшөө дурсгалын гэх мэт байгууламж байж болно.


5.21.2. Зул мандаах өргөөг тусдаа байгууламжид байрлуулан гар ариутгах боломж бүхий тоноглолоор тоноглоно.

5.21.3 Булшны байгууламж: Газрын хөрсөнд оршуулах булшны нүх нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- I. Нүхний гүн газрын гадаргаас 1,5м-ээс ихгүй
- II. Шарил хоорондын зай булангийн ирмэгээс хэмжсэнээр 2м-ээс ихгүй
- III. Газрын хэвгий хэсэгт налуу бус эгц доошоо ухагдсан байх.


5.21.4 Хажуугийн булшинд хүндэтгэлтэй хандаж дундын зай бүхий орчныг цэвэр байлгахаар төлөвлөнө.





Зураг 6. Гадна байгууламжийн жишээ зураг

5.21.5 Шарилын хөшөө: Нас барсан хүний тухай дурсамжийг хадгалах зорилготой дурсгалын мэдээлэл агуулсан архитектурын байгууламж, хөшөө, баримал, чулуу зэргийг байрлуулахаар төлөвлөж болно.



Зураг 7. Шарилын хөшөөний жишээ зураг

5.21.6. Газрын гадарга дээр байрлуулах хөшөө, дурсгалын байгууламжийн овор хэмжээ, зай талбайг тухайн газар нутгийн газарзүйн тогтоц, байгалийн онцлог, зан заншилд тохируулан тодорхой хязгаарлалт хэмжээг орон нутгийн эрх бүхий байгууллагаас тогтоогоогүй тохиолдолд олгосон газарт багтаан байрлуулахаар төлөвлөлтийг хийнэ.

5.21.7. Байгалийн чулууг ашиглах тохиолдолд тухайн газар орны цаг уур, хөрсний шинж чанараас шалтгаалан хүндийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх.


5.21.8. Шарилын хөшөөний хэмжээг 50см х 80см—ээс ихгүй байхаар хязгаарласнаар байгалийн чулууны нөөцийг хэмнэх, оршуулгын үйлчилгээний үнэ тарифын хэлбэлзлийг багасган, шарилын хөшөөний хэмжээ нэгэн жигд болж, ялгавартай байдлыг багасгана.

5.22. Булшны талбайн төлөвлөлтийг хийхдээ дараахыг харгалзан үзнэ<sup>6</sup>. Үүнд:

<sup>6</sup> <https://www.codepublishing.com/WA/Roslyn/html/Roslyn12/Roslyn1245.html>

А. Насанд хүрэгчдийн булшны талбайн хувьд хэмжээ нь 1 м өргөнтэй, 2-2.5 метр урттай байна. Хүүхэд болон нялхсын булшны талбайн хувьд хэмжээ 1 м өргөнтэй, 1.5 м урттай;

В. Насанд хүрэгчдийн талбайн хувьд жийргэвчний хэмжээс нь 1.2 м өргөнтэй, 3 м урттай байна. Хаалтны өнгө нь саарал эсвэл цагаан өнгөтэй байна.



Зураг 8. Төлөвлөлтийн план зураг

5.24. Хөшөө<sup>7</sup> барлуулах төлөвлөлт: Хөшөө нь суурин дээр байх ёстой. Хөшөө, суурийн нийт хэмжээг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- Том хөшөө дурсгалууд: 60-110 см урт, 20-30 см өргөн, 30-90 см өндөр;
- Жижиг дурсгалууд: 60-110 см урт, 20-30 см өргөн, 30 см хүртэл өндөр.

5.24.1. Хөшөө, суурь нь бетон суурь дээр тулгуурлана. Тулгуур нь суурийн периметрээс 10 см урт байна. Том хөшөөг 120 см-ын гүнд, жижиг хөшөөг 60 см-ын гүнд суурилуулахаар бэлтгэгдсэн байна. Суурь нь өөр булшинд хүрч болохгүй. Хөшөөг булшны төгсгөлөөс унших боломжтой байхаар хийх шаардлагатай.

5.25. Хашаа<sup>8</sup>: Оршуулгын газрыг харах боломжтой буюу нэвт харагддаг байхаар хашааг хийнэ.

5.25.1. Оршуулгын газрын хашаанд дараах шаардлагыг хангуулсан байна<sup>9</sup>. Үүнд:


1. Зөвшөөрөгдсөн материалаар баригдсан байх;
2. Өндөр нь 2 метрээс хэтрэхгүй байх;
3. Багануудын хоорондох зай нь 2.5 метрээс хэтрэхгүй байх ёстой;
4. Гинжин хэлхээтэй хашлага нь дараах өнгөтэй байна.
  - а. Саарал;
  - б. Хар;
  - с. Цагаан.

<sup>7</sup> <https://www.dowr.org/img/Cemetery%20Rules%20and%20Regulations.pdf>

<sup>8</sup> <https://www.codepublishing.com/WA/Roslyn/html/Roslyn12/Roslyn1245.html>

<sup>9</sup> <https://www.codepublishing.com/WA/Roslyn/html/Roslyn12/Roslyn1245.html>





Зураг 8. Орц гарцын төлөвлөлтийн жишээ зураг

5.25.3. Оршуулгын газар нь өөр оршуулгын газартай хиллэдэг бол оршуулгын газруудын хооронд явган хүний хөдөлгөөнийг хангах үүднээс хашаанд явган хүний хаалга суурилуулана.

5.25.4. Давхар гогцоотой буржгар утсан (нэхмэл утас) хашаа барихад дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


1. Хашааны өндөр нь 75-120 см-ийн хооронд байна.
2. Хашааны тулгуур нь 2 метрийн хэмжээтэй, хуш модон материалтай байна.
3. Гадсууд хоорондоо 2.5 метрээс илүүгүй зайтай байна.
4. Хөндлөвч нь хамгийн багадаа 2 метрт 60 см байх ёстой.
5. Хөндлөвчинд утсыг хүнд даацын ац хадаасаар бэхэлнэ.
6. Гадасны гүн нь хамгийн багадаа 75 см байна. Доод талыг нь 15-20 см хүртэл вандуйн хайргаар хийж, түүн дээр 60 см цементээр дүүргэнэ. Гадас нь вандуйн хайрганы орой дээр байрлана.


5.26. Оршуулгын газрын тэмдэг төлөвлөхдөө дараах байдлаар хийнэ. Үүнд:

1. Тэмдгийн материал мод эсвэл модоор бүрсэн байж болно. Хуш модны материал илүү тохоиромжтой.
2. Тэмдгүүд нь байгалийн модны өнгөтэй байна. Үсгийг мод руу чиглүүлж, хар эсвэл цагаанаар будна.
3. Оршуулгын газарт нэгээс олон самбар ашиглаж байгаа бол эргэхээс сэргийлж бэхэлсэн арын бэхэлгээ (шонгийн хоёр талд нэг оосор) ашиглана. Туузны өргөн нь 3 см-ээс ихгүй байна.
4. Оршуулгын газрын тэмдгийн хамгийн дээд хэмжээ нь 240 см өндөр, 60 см өргөн байна. Өндрийг самбарын дээд хэсгээс тавцангийн ёроол хүртэл хэмжинэ.
5. Оршуулгын газрын тэмдгийн эцсийн байрлалыг оршуулгын газрын үзэмжид саад учруулахгүйгээр зочдод хамгийн их харагдахуйц байлгах үүднээс оршуулгын газраас тогтооно.

5.26.1. Чиглэл ба мэдээллийн тэмдгийг дараах байдлаар төлөвлөнө.

1. Металл материалтай байна. Өнгөний схем нь цагаан үсэг бүхий бор дэвсгэртэй байна.
2. Чиглэлийн тэмдэг нь замын тэмдгийн стандартыг хангасан байна. Мэдээллийн тэмдэг нь 75-120 см-ээс ихгүй, тэгш өнцөгт хэлбэртэй байна.





Зураг 9. Чиглэлийн тэмдэг, ангилал хийх жишээ зураг

5.26.2. Хөшөөний тэмдэг: Хөшөөний бүх загвар, өнгө нь оршуулгын газраар батлагдсан байна. (зарим тохиолдолд үүнд хувь хүний талбайн булшны хөшөө хамаарахгүй байж болно).


1. Материал нь гантиг, бетон, боржин чулуу байх нь зохимжтой. Үсгийг сийлбэрлэсэн байна.
2. Тэмдгийг аль болох бага байлгахыг зөвлөж байна, гэхдээ 2 метрийн зайнаас уншиж болохуйц байна.

## 5. ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА

5.1. Оршуулгын газрын хөрс, орчныг улирал тутам нэг удаа мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх ба жилд 2 удаа /хавар, намрын улиралд/ шавьж, мэрэгч устгалын ажлыг хийлгэх ба шаардлагатай тохиолдолд тухай бүр нэмэлтээр хийлгэнэ.<sup>10</sup>


<sup>10</sup> MNS 6841:2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага

Усны нөөцөд үзүүлэх оршуулгын газрын нөлөөг доорх жишээ зургаар үзүүлэв.



5.2. Газар доорх усны давхаргад савны нөлөө /bucket effect/ гэх нөлөөлөл үйлчилдэг бөгөөд байгалийн хөрстэй харьцуулахад булшны хөрс бага нягтаршилтай тул сайн нэвчүүлдэг. Шороогоор дүүргэсэн булшны орчмыг ус дүүргэж, гадаргын гүнд нэвчинэ.

5.3. Гадаргын болон гүний усны харилцан үйлчлэл




5.4. Гүний болон гадаргын ус байнгын харилцан үйлчлэлд байдаг. Гадаргын ус газар доорх усаар тэжээгддэг. Гадаргын болон гүний усны дунд хөрсөн давхарга байгаа нь шууд харилцан үйлчлэхээс сэргийлдэг боловч хөрсөн давхарга дахь усны хөдөлгөөнөөр харилцан үйлчлэлцэж байдаг.

5.5. Хөрсний чулуулгийн орчин: Хөрс чулуулгийн орчинд булш ухсан эсэх нь гадаргын чийг чулуулгийн дээд хэсгийн шороо эсвэл хагаралд нэвчихэд чухал нөлөө үзүүлнэ. Энэ нь дараа нь булш хатсан, үерт автсан, булшинд ус хуримтлагдсан эсэх, булшин дахь исэлдэлтийн нөхцөл байдал ямар байх зэрэгт нөлөөтэй.

5.6. Дүүргэлтийн материалын шинж чанаруудтай хослуулан дүүргэсэн булш нь булш руу эсвэл булшнаас усыг холдуулах боломжтой бөгөөд үүнээс цааш гүн нэвчилт нь хөрс ба үндсэн чулуулгийн хоорондох орчны гүн болон шинж чанарт нөлөөлнө.

5.7. Оршуулгын газар, хог хаягдлын зориулалтын цэг, ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу байгуулж, ашиглах шаардлагатай.

5.8. Хог хаягдлын цэг, ариун цэврийн байгууламж, оршуулгын газарт эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангасан байна.



## 6. ОРШУУЛГЫН ГАЗРЫГ ХААХ ШААРДЛАГА

6.1. Дараах тохиолдолд оршуулгын газрыг хаана. Үүнд:

- Тухайн оршуулгын газарт оршуулга хийх газрын нөөц дууссан.
- Тухайн газарт оршуулгын үйл ажиллагаа 5-с дээш жил хийгдээгүй.
- Байгалийн гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйлийн улмаас оршуулгын газар эвдэж сүйдсэн, сэргээн засварлах боломжгүй болсон.
- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас оршуулгын газрыг үргэлжлүүлэн ашиглах нь хүн амын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан талаар дүгнэлт гаргасан.
- Хаагдсан оршуулгын газрыг арчилж хамгаалах ажлыг тухайн дүүргийн Засаг дарга хариуцах ба арчлалт хамгаалалтын ажилд шаардагдлагатай төсвийг дүүргийн урсгал төсөвт жил бүр тусгуулж, зөвшөөрөлтэй болон хаагдсан оршуулгын газрын хамгаалалтын бүсэд бусад зориулалтаар газар олголт хийлгэхгүй байхад хяналт тавьж ажиллана.

6.2. Хаагдсан оршуулгын газрыг хариуцах этгээдийг тухайн орон нутгийн эрх бүхий байгууллагаас томилж, нөхөн сэргээлт, арчилгааг хариуцуулж болно.

## 7. ОРШУУЛГЫН ГАЗРЫГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ШААРДЛАГА

7.1. Зөвшөөрөлгүй газар оршуулсан болон ил тавьсан шарилыг талийгаачийн ар гэрийнхний зөвшөөрлийг авахгүйгээр шилжүүлэн чандарлах ба энэ тухай шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хандан оршуулгын үйлчилгээ



эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага тухайн оршуулга байгаа дүүргийн цагдаагийн байгууллагын хяналтан дор гүйцэтгэнэ.

7.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нийслэлийн нутаг дэвсгэрт ил тавьсан шарил болон зөвшөөрөлгүй оршуулсан шарилын талаарх мэдээллийг тухайн дүүргийн цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

7.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн мэдээллийн дагуу тухайн нутаг дэвсгэрийг хариуцсан цагдаагийн байгууллага болон шүүхийн шинжилгээний байгууллага шарилд газар дээр нь үзлэг хийх ба тэдний зөвшөөрөл, дүгнэлтийг үндэслэн шарилыг шилжүүлэн чандарлана.

7.4. Зөвшөөрөлтэй оршуулгын газар байгаа шарилыг талийгаачийн ар гэрийнхний хүсэлтээр шилжүүлэн чандарлаж болох ба энэ тохиолдолд гарах зардлыг талийгаачийн ар гэрийнхэн хариуцна.

7.5. Дэд бүтцийн барилга байгууламж барих зорилгоор оршуулгын газраас хэсэгчлэн шарил шилжүүлэх тохиолдолд Нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэр гаргаж, холбогдох эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Шарил шилжүүлэх үед шарилын хайрцаган дотроос гарсан эд зүйлс, эдлэл хэрэглэл, үнэт зүйлсийг чандарын суваргад хамтад нь зална.

7.6. Ил тавьсан шарилын талаарх мэдээллийн дагуу цагдаагийн байгууллага шарил байгаа газар дээр үзлэг хийж, шарилыг шүүхийн шинжилгээний байгууллагад шилжүүлнэ.

7.7. Шүүхийн шинжилгээний байгууллага нь ил тавьсан тухайн шарилыг шинжилж, гэмт хэргийн шинж илрээгүй гэж үзвэл цагдаагийн байгууллагын зөвшөөрлөөр ар гэрийнхэнд нь шилжүүлж болно. Хэрэв тухайн шарилын хэн болох, ар гэрийнхэн нь 30 хоногийн хугацаанд тогтоогдоогүй тохиолдолд шүүхийн шинжилгээний байгууллага шарилыг зөвшөөрөлтэй оршуулгын газарт далд оршуулна.

7.8. Шарил шилжүүлэн оршуулах ажил гүйцэтгэхдээ хөндсөн шарилын нүхийг хөрсөөр хучиж тэгшлэн хог хаягдлыг бүрэн цэвэрлэнэ.

## **8. АНХААРАХ БОЛОН ХОРИГЛОХ ЗҮЙЛС**

8.1 Оршуулгын газарт байрлах булш бүр дугаартай байх бөгөөд түүний байрлал болон холбогдох мэдээлэл бүртгэлд заавал тусгаж бичсэн байна.

8.2 Оршуулгын газрын ерөнхий өнгө үзэмж, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн барилга байгууламж барих, угсрах, нүүлгэхээс сэргийлж болно.

8.3 Мод, бут сөөг, ургамлыг гэмтээж, устгаж болохгүй.

8.4 Зүлгэн дээр тээврийн хэрэгсэл жолоодохгүй, тогтоосон замаас бусад газарт машинаа зогсоож болохгүй.

8.5 Ан агнах, галт зэвсэг, түүний дотор хийн буу (оршуулгын зан үйлийг дагаж мөрдөхөөс бусад тохиолдолд) хийхийг хориглоно.

8.6 Байнгын болон явуулын худалдаа хийх, гуйлга гуйх, сурталчлах, аливаа сурталчилгаа түгээх, байрлуулахыг хориглоно.

8.7 Хөшөө дурсгалт байгууламжийн эргэн тойронд сурталчилгааны самбар, таблет байрлуулахыг хориглоно. Оршуулгын газрын аль ч хэсэгт зар сурталчилгааны хэлбэрийг байрлуулахыг хориглоно.

8.8 Галын аюулгүй байдлыг хангахдаа Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийг баримтална.


8.9. Уламжлалт оршуулгын газарт мод, төмөр, металл дурсгал, шахмалуудыг оршуулгын газарт оруулахыг хориглоно.<sup>11</sup>

8.10. Арчилгааг дараах байдлаар хийнэ. Үүнд:

- Арчилгаанд өвс хадах, тайрах, зам засварлах, хонхойсон булш, тэмдэглэгээг тэгшлэх, ургамал тарих зэрэг ажлууд багтана.
- Байнгын арчилгаа нь тэмдэглэгээ, хөшөө дурсгал, суурийг засварлах, солих зэрэгт хамаарахгүй. Оршуулгын газрын талбай болон булшны зайд бут сөөг тайрах.
- Хортой, цочромтгой, өргөстэй, жимсний мод, шүүс дусдаг ургамлыг сонгож болохгүй.

8.11. Хог хаягдал, хогийн ургамал, ялзарсан цэцэг, ургамлыг хаях зориулалтын хогийн савтай байна.

8.12. Ургамал: Ургамлын өндөр 15-20 см байх.



8.12.1 Нэг наст цэцэг, олон наст ургамлыг боржин чулуу, хар гантиг, цемент, ширмэн, удаан эдэлгээтэй хуванцраар хийсэн сав, вааранд суулгана.

8.12.2 Бүх сав, ваарыг сайн нөхцөлд хадгалах ёстой. Төмөр ваарыг зохих ёсоор будсан байх ёстой.

8.12.3 Сарнайн бут, цахилдаг, хөндийн сараана болон арчилгаа их шаарддаг олон наст ургамлуудыг тарихыг хориглоно. Боломжтой бол тухайн бүс нутгийн уугуул ургамлуудыг сонгох нь арчилгаа бага шаарддаг бөгөөд өвчин, шавьжид тэсвэртэй байдаг. Хэрэв уугуул ургамлын төрөл зүйл хязгаарлагдмал бол тухайн бүс нутагт сайн зохицдог ургамлыг сонго. Энэ нь хөрсний давхаргын аэробик/агааргүй нөхцөл өөрчлөгдөхөд нөлөө үзүүлж, зарим давс, металлыг хадгалах, түр зуур тунадасжуулах явцад органик буюу бичил биетний бохирдуулагчийг бууруулж болзошгүй.

<sup>11</sup> <https://www.hastings.gov.uk/Cemetery-crematorium/grave-types/>



8.12.4. Хөрсний давхаргад хадгалагдсан аливаа бохирдуулагч нь удаан үргэлжилсэн, хүчтэй аадар борооны дараа газар доорх усны түвшинд хүрч болно.

8.12.5. Оршуулгын газар нь хяналтын камертай байх ба суурилуулалтын өндөр нь 2.5м-5м байх нь зохимжтой. 2.5м өндөрт байрлуулсан хяналтын камер нь талбайг илүү ойр зайнаас харуулах бол 5м өндөрт байрлах нь эргэн тойрны талбайг илүү сайн хамруулж харуулдагийг анхаарах хэрэгтэй.

8.12.6. Камерыг булшны дэргэд байрлуулж болохгүй, камерын эргэлдэх чимээ нь булшийг эргэж очсон хүмүүст сонсогддог. Энэ нь хүмүүсийн нас барагсадтай салах ёс гүйцэтгэх, тэдний төлөө залбирахад саад болох тул тохиромжгүй.

8.12.7. Камерыг булшнаас тодорхой зайд, явган хүний зам дагуу гэрэлтүүлгийн шон дээр суурилуулах хэрэгтэй.<sup>12</sup>

*Хүснэгт. Камер төлөвлөхөд шаардагдах мэдээлэл<sup>13</sup>*

№	Байршил	Төрөл	Камерын тоо
1	Орох хаалга	Тоон эсвэл аналог	1
2	Гарах хаалга	Тоон эсвэл аналог	1
3	Орох хаалганы дагуу явган хүний зам	Тоон эсвэл аналог	1
4	Дугуйн зам	Тоон эсвэл аналог	1
5	Оршуулгын газрын төв цэг	Тоон эсвэл аналог	1

## 9. ШАЛГАХ ХУУДАС

*Хүснэгт . Шалгах хуудас*

№	Шалгуур үзүүлэлт	Тайлбар	
		Тийм	Үгүй
1	Оршуулгын газрын эзэмшил газрын хилийг тэмдэгжүүлэн стандартын дагуу хашаа байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Оршуулгын газрын гадна талбайд тухайн барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө, байршлын схем зургийг ойлгомжтойгоор самбарт байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

<sup>12</sup> <https://alarconespinosa.com/2020/05/14/two-steps-that-should-be-followed-when-installing-security-cameras-in-cemeteries/>

<sup>13</sup> <https://www.iobm.edu.pk/assets/documents/CCTV-Policy-July-2018.pdf>

3	Газарт оршоосон булшны чулууг дугаарлан холбогдох мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд хадгалсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Оршуулгын газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоон тэмдэгжүүлэн анхааруулах тэмдгийг баримт бичгийн дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Оршуулгын газрын эзэмшил газарт бусад зориулалтын барилга байгууламж байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Орц гарцыг хотын стандартын баримт бичгийн дагуу төлөвлөсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Гэнэтийн аваар осол, байгалийн гамшгийн үед хэрэглэх аюулын зарлан мэдээлэх төхөөрөмж байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Тээврийн хэрэгслийн зогсоолыг баримт бичгийн дагуу төлөвлөсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Оршуулгын газрын орчмыг камержуулсан эсэх		
10	Оршуулгын газрын гадна орчинд хотын стандартын баримт бичгийн дагуу гэрэлтүүлэг байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг хотын стандартын баримт бичгийн дагуу төлөвлөсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12	Халдваргүйжүүлэлтийг баримт бичигт заасан хугацаанд гүйцэтгэж тэмдэглэл хөтлөн баримтжуулдаг эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
13	Булш хоорондын зайг баримт бичигт заасны дагуу байрлуулсан эсэх		
14	Булшны бүрэн бүтэн байдал алдагдсан тохиолдол бүрийг тэмдэглэн цаг алдалгүй засварлан баримтжуулдаг эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
15	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэдэг эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Газрын тухай хууль
3. Соёлын өвийг хамгаалах тухай хууль
4. Байгаль орчны тухай багц хууль
5. MNS 5105:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага
6. MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
7. MNS 6841:2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага
8. MNS 5605:2006 Шарил чандарлах үйлчилгээний байгуулагад тавигдах ерөнхий шаардлага
9. БНБД 30-01-04 Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт
10. Standard operating procedure-(sop) close circuit television (cctv) operation (security department –iobm)
11. <https://alarconespinoza.com/2020/05/14/two-steps-that-should-be-followed-when-installing-security-cameras-in-cemeteries/>
12. <https://www.hastings.gov.uk/Cemetery-crematorium/grave-types/>
13. <https://www.dowr.org/img/Cemetery%20Rules%20and%20Regulations.pdf>
14. <https://www.codepublishing.com/WA/Roslyn/html/Roslyn12/Roslyn1245.html>